


Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын
09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт



ДААТГАГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ журмын зорилго нь даатгагч даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй эсэхийг тодорхойлох, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 Даатгагч нийт хөрөнгөөс хөрөнгө оруулалт хийхийн өмнө төлбөрийн чадварт нөлөөлөх дараах үзүүлэлтүүдийг авч үзнэ. Үүнд:

- 1.2.1 Гэнэтийн хүлээж болзошгүй эрсдэл;
- 1.2.2 Төлбөрийн чадварт нөлөөлөх эрсдэл;
- 1.2.3 Даатгуулагчаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн байдал;
- 1.2.4 Хөрөнгө оруулалтаас авсан өгөөж;
- 1.2.5 Эргэлтийн хөрөнгөөр төлбөр түргэн гүйцэтгэх чадвар;
- 1.2.6 Бусад шаардлагатай үзүүлэлтүүд.

1.3 Даатгагч төлбөрийн чадварыг тооцохдоо холбогдох эрх бүхий ажилтнаар баталгаажсан санхүүгийн тайлан, тэнцлийн үзүүлэлтүүдийг ашиглана.

1.4 Даатгагч энэ журмын 2.4 болон 3.4-т заасны дагуу хөрөнгөө байршуулахад Даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг харгалзахаас гадна дараах этгээдээс бусад этгээдэд хөрөнгө оруулалт байршуулж болно.

- 1.4.1 даатгалын тухай хуулийн 4.1.12-т заасан холбогдох этгээд;
- 1.4.2 барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь зээлийн үндсэн өр болон хүүгийн төлбөрийг барагдуулахад хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээд;
- 1.4.3 холбогдох этгээдтэй хэрэг, маргаан үүссэний улмаас эрх бүхий байгууллагаар хянагдаж, шалгагдаж байгаа этгээд;
- 1.4.4 даатгалын компани өөрөө холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.

Хоёр. Ердийн болон давхар даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт

2.1 Даатгагчийн төлбөрийн чадварын байдлыг төлбөрийн чадварын зохистой харьцаагаар тодорхойлно.

2.2 Төлбөрийн чадварын зохистой харьцааг даатгагчийн зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнг өр төлбөрийн дүн ба зайлшгүй байх хөрөнгийн нийлбэр дүнд хуваах замаар буюу дараах томъёогоор тооцно.

$$TЧЗХ = \frac{ЗХ}{(ЗБХ + \Theta T)} * 100\% , \text{ Үүнд:}$$

TЧЗХ – төлбөрийн чадварын зохистой харьцаа

ЗХ – зөвшөөрөгдөх хөрөнгийн дүн

ЗБХ – зайлшгүй байх хөрөнгийн дүн

ӨТ – өр төлбөрийн дүн

2.3 Зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнг даатгагчийн нийт хөрөнгөөс зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг хасах замаар буюу дараах томъёогоор тооцно.

$$ЗХ = НХ - ЗqX$$

, Үүнд:

ЗХ – зөвшөөрөгдөх хөрөнгийн дүн

НХ – нийт хөрөнгийн дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнгээс давхар даатгалын хойшлогдсон хураамж, нөхөн төлбөрийн нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсгийг хассан дүн/

ЗqX – зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн

2.4 Даатгагч нь дараах хүснэгтэд заасны дагуу хөрөнгийг ангилан, зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнг тооцох бөгөөд энэ журмын 3 дугаар хавсралтад заасан дансны жагсаалтыг ашиглана:

| № | Хөрөнгийн ангилал | Хөрөнгө байршуулах дээд хувь | Нэгжид ногдох хөрөнгийн дээд хувь | Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хувь |
|-------|--|------------------------------|-----------------------------------|--------------------------------|
| | | 1 | 2 | 3 |
| | Баганын дүн | | | |
| 2.4.1 | Банкны харилцах, хадгаламж /Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах банкинд байршуулсан/ | 100% | 35% | 0% |
| 2.4.2 | Гадаадын банкин дахь харилцах, хадгаламж, хадгаламжийн сертификат /Тухайн улсынхаа эрх бүхий байгууллагаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах "Стандарт энд Пурс" (Standard&Poor's) компанийн BBB болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй банкинд байгаа харилцах, хадгаламж, тус банкнаас гаргасан хадгаламжийн сертификат/ | 2% | 1% | 0% |
| 2.4.3 | Дотоодын банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулсан мөнгөн хөрөнгө /Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө/ | 20% | 5% | 5% |
| 2.4.4 | Бэлэн мөнгө | 2% | 2% | 0% |
| 2.4.5 | Хэвийн авлага | 20% | 20% | 0% |
| | Хугацаа хэтэрсэн авлага | 15% | 15% | 25% |
| | Хэвийн бус авлага | 10% | 10% | 50% |
| | Эргэлзээтэй авлага | 0% | 0% | 100% |

| | | | | | | |
|--------|---|--|------|------|--|-----|
| | Муу авлага | болон мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд тооцсон хүүний авлага, Банкинд байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын хүүний авлагын дун/ | 0% | 0% | 100% | |
| 2.4.6 | Банкны хадгаламжийн сертификат /Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах банкнаас олгосон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үнэт цаас/ | | 50% | 20% | 0% | |
| 2.4.7 | Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл | | 100% | 100% | 0% | |
| 2.4.8 | Төв банкны үнэт цаас /Монголбанкны мөнгөний бодлогын нээлттэй захын хэрэгсэл бөгөөд хямдруулсан хэлбэрээр арилжигдаж, тогтоосон хугацааны дараа нэрлэсэн үнээр эргэн төлөгдөх үнэт цаас/ | | 60% | 60% | 0% | |
| 2.4.9 | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан үнэт цаас/ | | 60% | 20% | Хэвийн үнэт цаас 0% Хугацаа хэтэрсэн үнэт цаас 25% Хэвийн бус үнэт цаас 50% Эргэлзээтэй үнэт цаас 75% Муу үнэт цаас 100% | |
| 2.4.10 | Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл | /Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.9-т заасан/ | | 60% | | 20% |
| 2.4.11 | Компанийн өрийн хэрэгсэл | | | 20% | | 10% |
| 2.4.12 | Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 1 ангилал | | 10% | 5% | 20% | |
| 2.4.13 | Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 2 ангилал | | 5% | 5% | 30% | |
| 2.4.14 | Хөрөнгө оруулалтын нээлттэй сан | /Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан/ | 20% | 10% | 5% | |
| 2.4.15 | Хөрөнгө оруулалтын хаалттай сан | | 20% | 10% | 10% | |
| 2.4.16 | Гадаадын Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл | /Хорооноос баталсан Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийх талаарх харилцааг зохицуулсан эрх зүйн | 2% | 1% | 0% | |
| 2.4.17 | Гадаадын Төв банкны үнэт цаас | | 2% | 1% | 0% | |
| 2.4.18 | Гадаадын компанийн өрийн | | 1% | 0,5% | 30% | |

| | | | | | |
|--------|--|---|------|------|------|
| | хэрэгсэл | актад заасан олон улсын хөрөнгийн биржүүд дээр арилжаалагдаж байгаа "Стандарт энд Пурс" (Standard&Poor's) компанийн BBB болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй Гадаадын засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл, Гадаадын Төв банкны үнэт цаас, түүнчлэн тус зэрэглэл болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй, холбогдох этгээдэд үл хамаарах Гадаадын компанийн хувьцаа, Гадаадын компанийн өрийн хэрэгсэл/ | 1% | 0,5% | 50% |
| 2.4.19 | Гадаадын компанийн хувьцаа | | | | |
| 2.4.20 | Давхар даатгалын хойшлогдсон хураамж /Хорооноос баталсан даатгагч даатгалын гэрээгээр хүлээсэн эрсдэлээ давхар даатгуулах талаарх харилцааг зохицуулсан журамд заасан "зөвшөөрөгдөх давхар даатгагч"-тай байгуулсан давхар даатгалын гэрээний дагуу төлөх ёстой хойшлогдсон давхар даатгалын хураамж/ | | 100% | 100% | 0% |
| 2.4.21 | Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг | | 100% | 100% | 0% |
| 2.4.22 | Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал | | 10% | 5% | 80% |
| 2.4.23 | Хэвийн өмчлөх бусад хөрөнгө | /Даатгалын нөхөн төлбөрийн тооцоолог хүлээн авсан хөрөнгө/ | 10% | 5% | 0% |
| | Хугацаа хэтэрсэн өмчлөх бусад хөрөнгө | | 5% | 2,5% | 25% |
| | Хэвийн бус өмчлөх бусад хөрөнгө | | 2,5% | 2,5% | 50% |
| | Эргэлзээтэй өмчлөх бусад хөрөнгө | | 0% | 0% | 100% |
| | Муу өмчлөх бусад хөрөнгө | | 0% | 0% | 100% |
| 2.4.24 | Санхүүгийн түрээс /Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 3.1, 3.2-т заасан/ | | 10% | 5% | 5% |
| 2.4.25 | Үл хөдлөх хөрөнгө /Даатгагчийн үндсэн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа Иргэний хуулийн 84.3 дахь хэсэгт заасан, холбогдох хууль, журмын дагуу баталгаажсан эрхийн гэрчилгээтэй үл хөдлөх хөрөнгө (Аливаа зээлийн барьцаанд тавьсан, эсхүл төлбөрийн баталгаа болгосон хөрөнгийг үл хөдлөх хөрөнгөнд оруулж тооцохгүй)/ | | 25% | 25% | 5% |

| | | | | |
|--------|--|-----|-----|------|
| 2.4.26 | Хөдлөх хөрөнгө /Даатгагчийн үндсэн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа биет үндсэн хөрөнгө буюу машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер дагалдах хэрэгсэл/ | 10% | 5% | 70% |
| 2.4.27 | Даатгалын үндсэн үйл ажиллагаанд зориулан авсан биет бус хөрөнгө | 10% | 10% | 70% |
| 2.4.28 | Бусад хөрөнгө /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнгээс энэ журмын 2.4.1-2.4.27-д заасан хөрөнгийн дүнг хасч тооцсон дүн/ | 0% | 0% | 100% |
| | Нийт хөрөнгийн дүн | | | |

2.5 Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг хөрөнгийн ангилал бүрээр байршуулах дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгийн дүн, нэгжид ногдох дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгийн дүн болон байршуулсан хөрөнгийн эрсдэлтэйд тооцсон хэсэг буюу зөвшөөрөгдөх хөрөнгийг бууруулах дүнгүүдийн нийлбэрээр дараах томъёогоор тооцож гаргана:

$$ЗqX = НХЗq + ХЗq_n + ЗХБ, \text{ Үүнд:}$$

ЗqX – зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн

НХЗq – нийт хөрөнгөнд ногдох зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн

ХЗq_n – нэгжид ногдох тухайн хөрөнгийн зөвшөөрөгдөхгүй дүн

ЗХБ – зөвшөөрөгдөх хөрөнгийг бууруулах дүн

2.6 Энэ журмын 2.4.5 “Эргэлзээтэй авлага”, “Муу авлага”, 2.4.23 “Эргэлзээтэй өмчлөх бусад хөрөнгө”, “Муу өмчлөх бусад хөрөнгө”, 2.4.28 “Бусад хөрөнгө”-ийн зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн нь зөвхөн эдгээр хөрөнгийн ангилал тус бүрээр байршуулах дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгийн дүнтэй тэнцүү байх бөгөөд эдгээр хөрөнгийн ангиллын дагуу зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хэмжээг тооцоход энэ журмын 2.5 дахь хэсэг хамаарахгүй.

2.7 Нийт хөрөнгөнд ногдох зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн ангилал тус бүрээр тооцсон зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгийн нийлбэрээр буюу дараах томъёогоор тооцно:

$$НХЗq = \sum_{i=1}^n [ХХ]$$

НХЗq – нийт хөрөнгөнд ногдох зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн

ХХ – зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгө

n – энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн ангиллын тоо

i – энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн ангиллын дугаар

2.7.1 Энэ журмын 2.4.1-2.4.19, 2.4.22-2.4.28-д заасан ангиллаарх нийт хөрөнгөнд ногдох зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан дүнг тухайн хөрөнгө байршуулах дээд хувийг нийт хөрөнгийн дүнгээр үржиж, үржвэрийг санхүүгийн байдлын тайлан дахь тухайн хөрөнгийн дүнгээс хасах замаар буюу дараах томъёогоор тооцно:

$$ХХ = (X_i - НХ * \max_i) \geq 0$$

, Үүнд:

X_i – санхүүгийн байдлын тайлан дахь тухайн хөрөнгийн дүн

НХ – нийт хөрөнгө

max_i – тухайн хөрөнгийг байршуулах дээд хувь

n – энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн ангиллын тоо

i – энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн ангиллын дугаар

2.7.2 Энэ журмын 2.4.20, 2.4.21-д заасан хөрөнгийн ангиллаарх нийт хөрөнгөнд ногдох зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан дүнг тухайн хөрөнгө байршуулах дээд хувийг санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнгээр үржиж, үржвэрийг санхүүгийн байдлын тайлан дахь тухайн хөрөнгийн дүнгээс хасах замаар тооцож гаргана.

2.8 Нэгжид ногдох зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн ангилал бүрээр тооцсон нэгжид ногдох зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгийн нийлбэрээр буюу дараах томъёогоор тооцно:

$$HXZq = \sum_{i=1}^n [XX_i^H], \text{ Үүнд:}$$

$HXZq$ – нэгжид ногдох зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн

XX^H – нэгжид зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгө

n – энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн ангиллын тоо

i – энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн ангиллын дугаар

2.8.1 Энэ журмын 2.4.1-2.4.19, 2.4.22-2.4.28-д заасан ангиллаарх нэгжид ногдох зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан дүнг тухайн хөрөнгөнд байршуулах нэгжид ногдох дээд хувийг нийт хөрөнгийн дүнгээр үржиж, үржвэрийг тухайн нэгжид байршуулсан хөрөнгийн дүнгээс хасах замаар буюу дараах томъёогоор тооцно:

$$XX^H = (X_i^H - HX * \max_i^H) \geq 0, \text{ Үүнд:}$$

X_i^H – тухайн нэгжид ногдох хөрөнгийн дүн

HX – нийт хөрөнгийн дүн

\max_i^H – нэгжид ногдох хөрөнгийн дээд хувь

i – энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн ангиллын дугаар

2.8.2 Энэ журмын 2.4.20, 2.4.21-т заасан хөрөнгийн ангиллаарх нэгжид ногдох зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан дүнг тухайн хөрөнгөнд байршуулах нэгжид ногдох дээд хувийг санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнгээр үржиж, үржвэрийг тухайн нэгжид байршуулсан хөрөнгийн дүнгээс хасах замаар тооцож гаргана.

2.9 Зөвшөөрөгдөх хөрөнгийг бууруулах дүнг энэ журмын 2.4.1-2.4.8, 2.4.12-2.4.28-д заасан хөрөнгийн зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа дүнг энэ журмын 2.4-т заасан зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн харгалзах хувиар үржүүлж, Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, Компанийн өрийн хэрэгслийн энэ журмын 2.11-д заасан ангиллаарх хөрөнгийн дүнг энэ журмын 2.4-т заасан тухайн ангилалд харгалзах зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хувиар үржүүлэн, эдгээр үржвэрүүдийг нэмэх замаар буюу дараах томъёогоор тооцно:

$$ЗХБ = \sum_{i=1}^n (AX_i * ZqXX_i), \text{ Үүнд:}$$

$ЗХБ$ – зөвшөөрөгдөх хөрөнгийг бууруулах дүн

AX_i – энэ журмын 2.4.1-2.4.8, 2.4.12-2.4.28-д ангиллаарх заасан хөрөнгийн зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа хөрөнгийн дүн, Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, Компанийн өрийн хэрэгслийн хувьд энэ журмын 2.10.3-т заасан ангиллаарх хөрөнгийн дүн

$ZqXX_i$ – энэ журмын 2.4-т заасан зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хувь

n – хөрөнгийн ангиллын тоо

i – хөрөнгийн ангиллын дугаар

2.10 Даатгагчийн хөрөнгөөс авлага, үнэт цаас, өмчлөх бусад хөрөнгө хэлбэрээр үүссэн хөрөнгийг хугацааны үзүүлэлтээр нь ангилж даатгагчийн төлбөрийн чадварыг үнэлэхэд ашиглана.

2.11 Даатгалын компани нь үнэт цаас (Гадаад улсын үнэт цаас, Банкны хадгаламжийн сертификат, Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цааснаас бусад), өмчлөх бусад хөрөнгө, авлагыг дор дурдсан байдлаар тухай бүр ангилна:

2.11.1 Хэвийн

2.11.2 Хугацаа хэтэрсэн

2.11.3 Чанаргүй, үүнээс:

2.11.3.а Хэвийн бус

2.11.3.б Эргэлзээтэй

2.11.3.в Муу

2.12 Энэ журмын 2.11-д заасан активын ангиллыг хугацааны үзүүлэлтээр нь дор дурдсан байдлаар дүгнэнэ:

2.12.1 Дараах хүснэгтийн дагуу авлагыг төлөхөөр тохиролцсон огноо буюу бичгээр хийсэн хэлцэлд тусгагдсан төлөгдөх хугацаа дууссанаас хойшхи хугацаанаас эхлэн хугацааг тооцож дүгнэн, авлагыг ангилна: (авлагын төлөгдөх хугацааг 1 удаа 120 хүртэлх хоногоор сунгасан тохиолдолд тухайн авлагыг хэвийн авлагаар, 1 удаа 121-ээс дээш хоногоор сунгасан тохиолдолд эргэлзээтэй авлагаар, 2 ба түүнээс дээш удаа авлагын төлөгдөх хугацааг сунгасан тохиолдолд тухайн авлагыг эргэлзээтэй авлагаар тооцно. Эргэлзээтэй авлагаар тооцож эхэлснээс хойш 30 хоногийн дотор төлөгдөөгүй бол тухайн авлагыг муу авлагаар тооцно):

| Ангилал | Хэвийн | Хугацаа хэтэрсэн | Хэвийн бус | Эргэлзээтэй | Муу |
|--------------------|---------------------------------|----------------------------------|----------------------------------|-----------------------------------|--|
| Хугацааны үзүүлэлт | 30 хүртэл хоногийн дотор байгаа | 31-60 хоногийн дотор төлөгдөөгүй | 61-90 хоногийн дотор төлөгдөөгүй | 91-120 хоногийн дотор төлөгдөөгүй | 121-ээс дээш хоногоор төлөгдөөгүй буюу гэмт хэргийн улмаас бий болсон авлага |

2.12.2 Дараах хүснэгтийн дагуу үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлтийн хуваарьт заасан хугацаанаас эхлэн хугацааг тооцож дүгнэн, Гадаад улсын үнэт цаас, Банкны хадгаламжийн сертификат, Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, Хөрөнгө оруулалтын сан болон хөрөнгийн биржийн хувьцаанаас бусад үнэт цаасыг ангилна:

| Ангилал | Хэвийн | Хугацаа хэтэрсэн | Хэвийн бус | Эргэлзээтэй | Муу |
|--------------------|--|---|--|--|--|
| Хугацааны үзүүлэлт | Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт, хуваарьт заасан хугаандаа төлөгдөж байгаа | Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 30 хүртэл хоног хэтэрсэн | Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 31-60 хоног хэтэрсэн. | Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 61-90 хоног хэтэрсэн. | Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 91-ээс дээш хоног хэтэрсэн. |

2.12.3 Дараах хүснэгтийн дагуу өмчлөлд авснаас хойшхи хугацаанаас эхлэн хугацааг тооцон дүгнэж, өмчлөх бусад хөрөнгийг ангилна:

| Ангилал | Хэвийн | Хугацаа хэтэрсэн | Хэвийн бус | Эргэлзээтэй | Муу |
|--------------------|--|---|---|--|--|
| Хугацааны үзүүлэлт | Өмчлөлд авснаас хойш 30 хүртэл хоногийн дотор борлогдоогүй | Өмчлөлд авснаас хойш 31-60 хүртэл хоногийн дотор борлогдоогүй | Өмчлөлд авснаас хойш 61-90 хүртэл хоногийн дотор борлогдоогүй | Өмчлөлд авснаас хойш 91-120 хүртэл хоногийн дотор борлогдоогүй | Өмчлөлд авснаас хойш 121 хоногоос дээш хоногийн хугацаанд борлогдоогүй |

2.13 Ердийн даатгагчийн өр төлбөрийн дүнг даатгагчийн нийт өр төлбөрийг даатгагчид ногдох орлогод тооцоогүй хураамжийн нөөц, давхар даатгалын хойшлогдсон шимтгэлийн орлогын дүнг тус бүр 10 хувиар бууруулах замаар буюу дараах томъёогоор тооцно.

$$\Theta T = H \Theta T - (\Theta T X H + \text{ДДХШО}) * 10\% , \text{ Үүнд:}$$

ΘT – өр төлбөрийн дүн

$H \Theta T$ – нийт өр төлбөрийн дүн /Санхүүгийн байдлын тайлангийн нийт өр төлбөрийн дүнгээс даатгалын нөөц сан дахь давхар даатгагчид ногдох хэсгийг хассан дүн/

ОТХН – даатгагчид ногдох орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн дүн /Санхүүгийн байдлын тайлангийн орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн дүнгээс давхар даатгалын хойшлогдсон хураамжийг хассан дүн/

ДДХШО- давхар даатгалын хойшлогдсон шимтгэлийн орлогын дүн

2.14 Давхар даатгагчийн өр төлбөрийн дүнг даатгагчийн нийт өр төлбөрийг даатгагчид ногдох орлогод тооцоогүй хураамжийн нөөц, алдагдлаас хамгаалах санг тус тус 10 хувиар бууруулах замаар буюу дараах томъёогоор тооцно.

$$\Theta T = H\Theta T - (OTXN + AXC) * 10\%$$

АХС- Алдагдлаас хамгаалах сан.

2.15 Даатгагч даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь зохих түвшинд биелүүлэхэд шаардлагатай хөрөнгө буюу зайлшгүй байх хөрөнгийн хэмжээг тооцохдоо энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу дараах 3 үзүүлэлтийн хамгийн их дүнг үндэслэн тогтоох буюу дараах томъёогоор тооцно:

$$ЗБХ = \max (OTXx; НХДx; ДСДХ)$$

ЗБХ – зайлшгүй байх хөрөнгийн хэмжээ

ОТХх – энэ журмын 2.15.1-д заасан дүн

НХДх – энэ журмын 2.15.2-д заасан дүн

ДСДХ – энэ журмын 2.15.3-д заасан дүн

2.15.1 Хураамжийн аргаар зайлшгүй байх хөрөнгийн хэмжээг тайлант хугацааны агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамжийн 40 хувь, бусад даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамжийн 20 хувийн нийлбэр дүнгээр буюу дараах томъёогоор тооцно;

$$OTXx = OTX^1 * 40\% + (HOTX - OTX^1) * 20\%$$

ОТХ¹ – Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн тайлант хугацаанд орлогод тооцсон хураамжийн дүн

НОТХ – Тайлант хугацааны нийт орлогод тооцсон хураамжийн дүн

2.15.2 Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн сүүлийн 3 жилд нэхэмжилсэн хохирлын дундаж дүнгийн 50 хувь дээр бусад хэлбэрийн сүүлийн 3 жилд нэхэмжилсэн хохирлын дундаж дүнгийн 20 хувийг нэмсэн дүн. Тус дүнг дараах томъёогоор тооцно;

$$НХДx = \frac{НХ^1_t + НХ^1_{t-1} + НХ^1_{t-2}}{3} * 50\% + \frac{((ННХ_t - НХ^1_t) + (ННХ_{t-1} - НХ^1_{t-1}) + (ННХ_{t-2} - НХ^1_{t-2}))}{3} * 20\%$$

Үүнд:

НХ¹_t - Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн тухайн жилийн тайлант хугацаанд нэхэмжилсэн хохирлын дүн

НХ¹_{t-1} - Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн өмнөх жилийн тайлант хугацаанд нэхэмжилсэн хохирлын дүн

НХ¹_{t-2} - Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн 2 жилийн өмнөх тайлант хугацаанд нэхэмжилсэн хохирлын дүн

ННХ_t - Тухайн жилийн тайлант хугацаанд нийт нэхэмжилсэн хохирлын дүн

ННХ_{г-1} - Өмнөх жилийн тайлант хугацаанд нийт нэхэмжилсэн хохирлын дүн

ННХ_{г-2} - 2 жилийн өмнөх тайлант хугацаанд нийт нэхэмжилсэн хохирлын дүн

2.15.3 Хорооноос тогтох дүрмийн сангийн доод хэмжээ

2.16 Нэхэмжилсэн хохирлын дүнг тухайн жилийн тайлант хугацаанд олгосон нөхөн төлбөрийн цэвэр зардал ба хохирлын төлбөрийн нөөц сангийн өөрчлөлтийн дүнгийн нийлбэрээс нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлтийг хасч тооцно.

2.17 Даатгагч нь 3-аас доош жил даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа тохиолдолд (даатгалын үйл ажиллагаа эрхэлж тусгай зөвшөөрөл олгогдоноос хойш 3 жил хүрэхгүй хугацаа өнгөрсөн) энэ журмын 2.15.2-т заасан үзүүлэлтийг тооцоолохгүй.

2.18 Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 110 хувь буюу түүнээс илүү байвал зохино.

2.19 Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа 100-аас 110 хувийн хооронд байвал тухайн даатгагчийг төлбөрийн чадваргүй болж болзошгүй гэж үзнэ.

2.20 Хэрэв даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа 100 хувиас доош байвал даатгагчийг төлбөрийн чадваргүй болсонд тооцно.

Гурав. Урт хугацаанд даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт

3.1 Урт хугацааны даатгагчийн төлбөрийн чадварын байдлыг төлбөрийн чадварын зохистой харьцаа, төлбөрийн чадварын хязгаар гэсэн 2 үзүүлэлтээр тодорхойлно.

3.2 Төлбөрийн чадварын зохистой харьцааг тооцоходоо даатгагчийн зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнг өр төлбөрийн дүнд харьцуулах замаар буюу дараах томъёогоор тооцно.

$$ТЧХ = \frac{ЗХ}{ЭТ} * 100\% \quad , \quad \text{Үүнд:}$$

ТЧХ – төлбөрийн чадварын зохистой харьцаа

ЗХ – зөвшөөрөгдөх хөрөнгийн дүн

ЭТ – өр төлбөрийн дүн

3.3 Зөвшөөрөгдөх хөрөнгийг даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнгээс зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг хасч тодорхойлно.

3.4 Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө гэж даатгалын компанийн төлбөрийн чадварын үзүүлэлтэд сөргөөр нөлөөлдөг хөрөнгийг хэлнэ. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийг тухайн хөрөнгийн дүнгээс дараах хувиар хасч тооцно:

| | | |
|----------|--|-----|
| 3.4.1 | Банкны харилцаа | 0% |
| 3.4.2 | Банкны хадгалалтын сертификат | 0% |
| 3.4.3 | Касс | 0% |
| 3.4.4 | Засгийн газрын өмчлөлтийн үйлчилгээ | 0% |
| 3.4.5 | Төв банкны үйлчилгээ | 0% |
| 3.4.6 | Давхар даатгалын үйлчилгээ | 0% |
| 3.4.7 | 90 хоногоос доош үлдэгдэлтэй хугацаанд төлөгдөөгүй байгаа авлага | 0% |
| 3.4.8 | Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үйлчилгээний үйлдвэрлэлд байгууллагад итгэлцлээр үл хамаарах банк бус санхүүгийн үйлчилгээнд байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө | 5% |
| 3.4.9 | Санхүүгийн байгууллагын үйлчилгээний ажиллагааны лизинг | 5% |
| 3.4.10 | Хөрөнгөөр байгууллагын үйлчилгээний үйлдвэрлэлд байгууллагад итгэлцлээр үл хамаарах банк бус санхүүгийн үйлчилгээнд байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө | 8% |
| 3.4.11 | Үл хөдлөх хөрөнгө | 8% |
| 3.4.12 | Хөрөнгө оруулалтын сан /Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан нээлттэй, эсхүл хаалттай сан/ | 10% |
| 3.4.12.а | Нээлттэй сан | 5% |
| 3.4.12.б | Хаалттай сан | 10% |

| | | |
|--|--------------------------------------|------|
| 3.4.13 | Орон нутгийн засаг захиргааны бонд | 10% |
| 3.4.14 | Компанийн бонд | 10% |
| 3.4.15 | Хуримтлал барьцаалсан зээл | 10% |
| 3.4.16 | МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа | |
| 3.4.16.а | I ангилал | 20% |
| 3.4.16.б | II ангилал | 30% |
| 3.4.17 | Бусад авлага | 100% |
| 3.4.18 | Биет бус хөрөнгө | 100% |
| 3.4.19 | Бараа, материал, тоног төхөөрөмж | 100% |
| 3.4.20 | Урьдчилж төлсөн зардал | 100% |
| 3.4.21 | Бусад хөрөнгө (даатгагчийн хөрөнгийн | |
| 3.4.1-3.4.20-д зааснаас бусад хөрөнгө) | | 100% |

3.5 Өр төлбөрийн дүнг даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн Өр төлбөр хэсэгт бичсэн дүнгээр тодорхойлно.

3.6 Төлбөрийн чадварын хязгаарыг тооцохдоо даатгагчийн зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнгээс өр төлбөрийн дүнг хасч тогтооно.

$$ТЧХ=(ЗХ-ӨТ)*100\% \quad , \quad \text{Үүнд:}$$

ТЧХ- Төлбөрийн чадварын хязгаар

3.7 Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааг энэ журмын 2.18-2.20-д заасны дагуу үнэлнэ.

3.8 Даатгагчийн төлбөрийн чадварын хязгаар нь даатгагчийн төлбөрийн чадварын хамгийн бага үзүүлэлттэй тэнцүү буюу түүнээс дээш байна.

3.9 Хэрэв даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа болон төлбөрийн чадварын хязгаарын аль нэг нь шаардлага хангаагүй бол тухайн даатгагчийг төлбөрийн чадваргүй болсонд тооцно.

3.10 Төлбөрийн чадварын хамгийн бага үзүүлэлт нь нөөцийн сангийн актуар тооцооллын хувь (3.10.1) ба даатгалын гэрээний эрсдэлтэй хэсгийн үнэлгээний хувь (3.10.2)-ийн нийлбэртэй тэнцүү байх бөгөөд хэрэв энэ нийлбэр нь зайлшгүй байх хөрөнгийн хэмжээ (3.10.3)-нд хүрэхгүй тохиолдолд зайлшгүй байх хөрөнгийн хэмжээ (3.10.3)-ээр тооцож байна. Үүнд:

3.10.1 Нөөц сангийн актуар тооцооллын хувь. Үүнийг өмнөх санхүүгийн жилийн эцсийн байдлаарх дараах үзүүлэлтүүдийн нийлбэрээр тодорхойлно:

3.10.1.а Гэрээний үргэлжлэх хугацаанд даатгуулагч нь даатгалын компанийн ашгаас ногдол ашиг авах талаар гэрээнд заагаагүй урт хугацааны даатгалын гэрээ буюу хувь оролцоогүй гэрээний нөөц сангийн 3 хувь;

3.10.1.б Гэрээний үргэлжлэх хугацаанд даатгуулагч нь даатгалын компанийн ашгаас ногдол ашиг авах нөхцөл бүхий урт хугацааны даатгалын гэрээ буюу хувь оролцоотой гэрээний нөөц сангийн 2 хувь;

3.10.1.в Даатгалын хураамжийн зохих хэсэг нь даатгуулагчийн хүсэл сонирхол болон тодорхой гэрээнд заасан нөхцөлийн дагуу хөрөнгө оруулалтад байршдаг урт хугацааны даатгалын гэрээ буюу хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сангийн 1 хувь.

3.10.2 Даатгалын гэрээний эрсдэлтэй хэсгийн үнэлгээний хувь (өмнөх санхүүгийн жилийн төгсгөл дэх нийт даатгалын гэрээний эрсдэлтэй хэсгийн үнэлгээний 0.2 хувиар тооцно. Энэ нь давхар даатгалд шилжүүлсэн гэрээг хасаж тооцно);

3.10.3 Зайлшгүй байх хөрөнгийн хэмжээг Хорооноос тогтоосон даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээгээр тооцно.

Дөрөв. Хяналт, хариуцлага

4.1 Даатгагч нь энэ журмын 2.4 болон 3.4-т заасан хөрөнгийг гадаад улсад байршуулахаар бол Хороонд хүсэлтээ бичгээр тавих ба Хорооны хяналт шалгалтын асуудал эрхэлсэн газар зөвшөөрөл олгох эсэхийг даатгагч албан бичиг ирүүлсэн өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэж, хариуг даатгагчид албан бичгээр хүргүүлнэ.

4.2 Ердийн болон давхар даатгагч нь энэ журмын нэгдүгээр хавсралт “СЗХ04144” маягт болон хоёрдугаар хавсралт “СЗХ04145” маягтын дагуу өөрийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тооцоолон гаргаж, улирал бүр санхүүгийн тайлангийн хамт цаасаар болон цахимаар Хороонд хүргүүлнэ.

4.3 Урт хугацааны даатгагч нь энэ журмын тавдугаар хавсралт “СЗХ04146” маягтын дагуу өөрийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тооцоолон гаргаж, улирал бүр санхүүгийн тайлангийн хамт цаасаар болон цахимаар Хороонд хүргүүлнэ.

4.4 Даатгагч нь сар бүр, шаардлагатай гэж үзвэл тухайн бүрд төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тооцох боломжтой байх шаардлагатай.


4.5 Хороонд хүргүүлсэн төлбөрийн чадварын зохистой харьцааг үнэн зөв тооцоолсон эсэхэд Хорооны хяналт шалгалтын асуудал эрхэлсэн газар хяналт тавьж, баталгаажуулах бөгөөд Даатгагчаас ирүүлсэн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн тайлантай холбогдуулан шаардлагатай гэж үзвэл Хороо нэмэлт мэдээлэл, материал шаардаж болно.

4.6 Энэ журамд заасны дагуу даатгагч төлбөрийн чадваргүй болж болзошгүй болсон тохиолдолд Хорооноос тогтоосон хугацаанд энэхүү нөхцөл байдалд хүргэсэн хүчин зүйлүүдийг тодорхойлж, тэдгээрийн нөлөөллийг үе шаттайгаар бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан Хороонд хүргүүлнэ.

4.7 Хороо энэ журмын 4.6-д заасан төлөвлөгөөг хянаж, шаардлагатай тохиолдолд даатгагчид зөвлөмж хүргүүлэн, тус төлөвлөгөөний дагуу ажиллаж буй эсэхэд хяналт тавина.

4.8 Хороо энэ журмын хэрэгжилтэд байнга хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт,
түүнд хяналт тавих журам”-ын 1 дүгээр хавсралт




**МАЯГТСЗХ04144. “.....” “ХХК-ийн 20... оны дүгээр улирлын
Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн**

| д/д | Хөрөнгийн ангилал | Хөрөнгө байршуулах дээд хувь | Зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа дүн | Нийт хөрөнгөнд ногдох зөвшөөрөгдөхгүй дүн | Нэгжид ногдох хөрөнгийн дээд хувь | Нэгжид ногдох зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа дүн | Нэгжид ногдох тухайн хөрөнгийн зөвшөөрөгдөхгүй дүн | Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хувь | Зөвшөөрөгдөх хөрөнгийг бууруулах дүн | Нийт зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн |
|-----|---|------------------------------|----------------------------------|---|-----------------------------------|--|--|--------------------------------|--------------------------------------|------------------------------------|
| | Баганын дүн | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1. | Банкны харилцах, хадгаламж | 100% | | | 35% | | | 0% | | |
| 2. | Гадаадын банкин дахь харилцах, хадгаламж, хадгаламжийн сертификат | 2% | | | 1% | | | 0% | | |
| 3. | Дотоодын банк бус санхүүгийн байгууллагад итгэлцдээр байршуулсан мөнгөн хөрөнгө | 20% | | | 5% | | | 5% | | |
| 4. | Бэлэн мөнгө | 2% | | | 2% | | | 0% | | |
| 5. | Хэвийн авлага | 20% | | | 20% | | | 0% | | |
| | Хугацаа хэтэрсэн авлага | 15% | | | 15% | | | 25% | | |
| | Хэвийн бус авлага | 10% | | | 10% | | | 50% | | |
| | Эргэлзээтэй авлага | 0% | | | 0% | | | 100% | | |
| | Муу авлага | 0% | | | 0% | | | 100% | | |
| 6. | Банкны хадгаламжийн сертификат | 50% | | | 20% | | | 0% | | |
| 7. | Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл | 100% | | | 100% | | | 0% | | |
| 8. | Төв банкны үнэт цаас | 60% | | | 60% | | | 0% | | |
| 9. | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас | 60% | | | 20% | | | 0% | | |
| | | | | | | | | 25% | | |
| | | | | | | | | 50% | | |
| | | | | | | | | 75% | | |

| | | | | | | | | | |
|-----|---|------|--|--|------|--|------|--|--|
| | | | | | | | 100% | | |
| 10. | Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл | 60% | | | 20% | | 0% | | |
| | | | | | | | 25% | | |
| | | | | | | | 50% | | |
| | | | | | | | 75% | | |
| | | | | | | | 100% | | |
| 11. | Компанийн өрийн хэрэгсэл | 20% | | | 10% | | 0% | | |
| | | | | | | | 25% | | |
| | | | | | | | 50% | | |
| | | | | | | | 75% | | |
| | | | | | | | 100% | | |
| 12. | Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 1 ангилал | 10% | | | 5% | | 20% | | |
| 13. | Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 2 ангилал | 5% | | | 5% | | 30% | | |
| 14. | Хөрөнгө оруулалтын нээлттэй сан | 20% | | | 10% | | 5% | | |
| 15. | Хөрөнгө оруулалтын хаалттай сан | 20% | | | 10% | | 10% | | |
| 16. | Гадаадын Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл | 2% | | | 1% | | 0% | | |
| 17. | Гадаадын Төв банкны үнэт цаас | 2% | | | 1% | | 0% | | |
| 18. | Гадаадын компанийн өрийн хэрэгсэл | 1% | | | 0,5% | | 30% | | |
| 19. | Гадаадын компанийн хувьцаа | 1% | | | 0,5% | | 50% | | |
| 20. | Давхар даатгалын хойшлогдсон хураамж | 100% | | | 100% | | 0% | | |
| 21. | Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг | 100% | | | 100% | | 0% | | |
| 22. | Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал | 10% | | | 5% | | 80% | | |
| 23. | Хэвийн өмчлөх бусад хөрөнгө | 10% | | | 5% | | 0% | | |
| | Хугацаа хэтэрсэн өмчлөх бусад хөрөнгө | 5% | | | 2,5% | | 25% | | |
| | Хэвийн бус өмчлөх бусад хөрөнгө | 2,5% | | | 2,5% | | 50% | | |
| | Эргэлзээтэй өмчлөх бусад хөрөнгө | 0% | | | 0% | | 100% | | |
| | Муу өмчлөх бусад хөрөнгө | 0% | | | 0% | | 100% | | |
| 24. | Санхүүгийн түрээс | 10% | | | 5% | | 5% | | |
| 25. | Үл хөдлөх хөрөнгө | 25% | | | 25% | | 5% | | |
| 26. | Хөдлөх хөрөнгө | 10% | | | 5% | | 80% | | |
| 27. | Даатгалын үндсэн үйл ажиллагаанд зориулан авсан биет бус хөрөнгө | 10% | | | 10% | | 70% | | |
| 28. | Бусад хөрөнгө | 0% | | | 0% | | 100% | | |
| | Нийт хөрөнгийн дүн | | | | | | | | |


“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт,
түүнд хяналт тавих журам”-ын 2 дугаар хавсралт



**МАЯГТСЗХ04145. “.....” “ХХК-ийн 20... оны дүгээр
улирлын төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт**

| Үзүүлэлт | Дүн | Тооцох хувь | Тооцсон дүн |
|--|-----|-------------|-------------|
| 1 | 2 | 3 | 4 |
| <i>1. Зайлиггүй байх хөрөнгө / $1 = \max(1.1, 1.2, 1.3)$ /</i> | | | |
| 1.1 Даатгалын хураамжид үндэслэх /Тухай тайлант хугацааны нийт орлогод тооцсон хураамж / $(1.1.1 (4)+1.1.2 (4))$ | | | |
| 1.1.1 Агаарын хөлөг, авто тээврийн хэрэгсэл, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамж | | 40% | |
| 1.1.2 Бусад хэлбэрийн орлогод тооцсон хураамж | | 20% | |
| 1.2 Даатгалын нэхэмжлэлд үндэслэх /Сүүлийн 3 жилийн дунджид үндэслэн/ $(1.2.1 (4)+1.2.2 (4))$ | | | |
| 1.2.1 Агаарын хөлөг, авто тээврийн хэрэгсэл, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн нэхэмжилсэн хохирлын дундаж дүн | | 50% | |
| 1.2.2 Бусад хэлбэрийн нэхэмжилсэн хохирлын дундаж дүн | | 20% | |
| 1.3 Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээ | | | |
| 2. Нийт хөрөнгө | | | |
| 3. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө | | | |
| 4. Зөвшөөрөгдөх хөрөнгө / $4 = (2) - (3)$ / | | | |
| 5. Өр төлбөр / $5 = \text{Нийт өр төлбөр} - \text{ОТХН} * 10\%$ / | | | |
| 6. Төлбөрийн чадварын зохистой харьцаа $/6 = 4 / (1+5) \geq 100\%$ | | | |

“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт,
түүнд хяналт тавих журам”-ын 3 дугаар хавсралт




Хөрөнгийн ангилал, дансны жагсаалтаар

| Хөрөнгийн ангилал | Дансны дугаар, тайлбар |
|---|--|
| Банкны харилцах, хадгаламж | 1110, 1111, 1120, 1121, 1140, 1141, 1310, 1317 эдгээр дансанд тусгагдсан Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах банкинд байгаа харилцах, хадгаламжийн дүн |
| Гадаадын банкин дахь харилцах, хадгаламж, хадгаламжийн сертификат | 1112, 1142, 1312 эдгээр дансанд тусгагдсан Гадаад улсын эрх бүхий байгууллагаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах “Стандарт энд Пурс” (Standard&Poor’s) компанийн BBB болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй банкинд байгаа харилцах, хадгаламж, тус банкнаас гаргасан хадгаламжийн сертификатын дүн |
| Дотоодын банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулсан мөнгөн хөрөнгө | 1130, 1131, 1313 эдгээр дансанд тусгагдсан Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн дүн |
| Бэлэн мөнгө | 1010, 1020, 1030 |
| Хэвийн авлага | 1160 - 1162, 1170, 1171, 1210, 1220, 1230, 1240, 1250, 1260, 1270, 1280, 1318, 1319, 1328, 2910 эдгээр дансанд тусгагдсан тохирох ангилал дахь авлагын дүн. 1219, 1229, 1239, 1249, 1259, 1269 дансдын дүн хэвийн авлагын дүнд тооцогдоно. |
| Хугацаа хэтэрсэн авлага | |
| Хэвийн бус авлага | |
| Эргэлзээтэй авлага | |
| Муу авлага | |
| Банкны хадгаламжийн сертификат | 1140, 1141, 1310, 1311 эдгээр дансанд тусгагдсан Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах банкнаас олгосон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үнэт цаасны дүн |
| Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл | 115001, 115101, 132001, 132101, 132201, 132301, 132601, 132701, 132901 эдгээр дансанд тусгагдсан Монгол Улсын засгийн газрын өрийн хэрэгслийн дүн |
| Төв банкны үнэт цаас | 115002, 115102, 132002, 132102, 132202, 132302, 132602, 132702, 132901 эдгээр дансанд тусгагдсан Монголбанкны мөнгөний бодлогын нээлттэй захын хэрэгсэл бөгөөд хямдруулса хэлбэрээр арилжигдаж, тогтоосон хугацааны дараа нэрлэсэн үнээр эргэн төлөгдөх үнэт цаасны дүн |
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас | 132003, 132103, 132203, 132303, 132603, 132703, 132901 эдгээр дансанд тусгагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан хөрөнгийн дүн |
| Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл | 132004, 132104, 132204, 132304, 132604, 132704, 132901 эдгээр дансанд тусгагдсан аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгслийн дүн |
| Компанийн өрийн хэрэгсэл | 132005, 132105, 132205, 132305, 132605, 132705, 132805, 132901 эдгээр дансанд тусгагдсан Хорооноос тусгай зөвшөөрөл авсан даатгагчийн |

| | |
|---|---|
| | холбогдох этгээдээс бусад компанийн өрийн хэрэгслийн дүн |
| Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 1 ангилал | 132106, 132206, 132306, 132606, 132706, 132806, 132901 эдгээр дансанд тусгагдсан уг ангиллаарх хөрөнгийн дүн |
| Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 2 ангилал | 132107, 132207, 132307, 132607, 132707, 132807, 132901 эдгээр дансанд тусгагдсан уг ангиллаарх хөрөнгийн дүн |
| Хөрөнгө оруулалтын нээлттэй сан | 132009, 132109, 132209, 132309, 132609, 132709, 132901 эдгээр дансанд тусгагдсан уг ангиллаарх хөрөнгийн дүн |
| Хөрөнгө оруулалтын хаалттай сан | 132009, 132109, 132209, 132309, 132609, 132709, 132809, 132901 эдгээр дансанд тусгагдсан уг ангиллаарх хөрөнгийн дүн |
| Гадаадын Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл | 115001, 115101, 132201, 132301, 132601, 132701, 132901 эдгээр дансанд тусгагдсан олон улсын хөрөнгийн биржүүд дээр арилжаалагдаж байгаа “Стандарт энд Пурс” (Standard&Poor’s) компанийн BBB болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй Гадаадын засгийн газраас гаргасан өрийн хэрэгслийн дүн |
| Гадаадын Төв банкны үнэт цаас | 132202, 132302, 132602, 132702, 132901 эдгээр дансанд тусгагдсан олон улсын хөрөнгийн биржүүд дээр арилжаалагдаж байгаа “Стандарт энд Пурс” (Standard&Poor’s) компанийн BBB болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй Гадаадын Төв банкны үнэт цаасны дүн |
| Гадаадын компанийн өрийн хэрэгсэл | 132205, 132305, 132605, 132705, 132901 эдгээр дансанд тусгагдсан Хорооноос баталсан Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийх талаарх харилцааг зохицуулсан эрх зүйн актад заасан олон улсын хөрөнгийн биржүүд дээр арилжаалагдаж байгаа “Стандарт энд Пурс” (Standard&Poor’s) компанийн BBB болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй холбогдох этгээдэд үл хамаарах Гадаадын компанийн өрийн хэрэгслийн дүн |
| Гадаадын компанийн хувьцаа | 132210, 132310, 132610, 132710, 132901 эдгээр дансанд тусгагдсан 132205, 132305, 132605, 132705, 132901 эдгээр дансанд тусгагдсан Хорооноос баталсан Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийх талаарх харилцааг зохицуулсан эрх зүйн актад заасан олон улсын хөрөнгийн биржүүд дээр арилжаалагдаж байгаа “Стандарт энд Пурс” (Standard&Poor’s) компанийн BBB болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй холбогдох этгээдэд үл хамаарах Гадаадын компанийн хувьцааны дүн |
| Давхар даатгалын хойшлогдсон хураамж | 1810 |
| Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг | 1820, 1821 |
| Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал | 1830, 1840, 1850 |
| Хэвийн өмчлөх бусад хөрөнгө | 1610 дансны тус ангилалд тохирох өмчлөх бусад хөрөнгийн дүн, 1619 дансны дүн нь хэвийн өмчлөх бусад хөрөнгийн дүнд тооцогдоно. |
| Хугацаа хэтэрсэн өмчлөх бусад хөрөнгө | |
| Хэвийн бус өмчлөх бусад хөрөнгө | |
| Эргэлзээтэй өмчлөх бусад хөрөнгө | |
| Муу өмчлөх бусад хөрөнгө | |
| Санхүүгийн түрээс | 2070, 2071 |
| Үл70, 2071 түрээсх | 2010, 2011, 2020, 2021 |
| Хөдлөх хөрөнгө | 2030, 2031, 2040, 2041, 2050, 2051, 2060, 2061 |
| Даатгалын үндсэн үйл ажиллагаанд зориулан авсан биет бус хөрөнгө | 2110, 2111, 2112, 2120, 2121, 2122, 2130, 2131, 2132, 2140, 2141, 2142, 2150, 2151, 2152, 2160, 2161, 2162, 2610 дансдын даатгалын үндсэн үйл ажиллагаанд зориулан авсан биет бус хөрөнгөнд хамаарах дүн. |


“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт,
түүнд хяналт тавих журам”-ын 4 дүгээр хавсралт



Зайлшгүй байх хөрөнгийн ангилал, дансны жагсаалтаар

| Даатгалын хэлбэр | Дансны дугаар | |
|---|--|---|
| | Орлогод тооцсон хураамж | Нэхэмжилсэн хохирлын дүн* |
| Автотээврийн хэрэгслийн даатгал | [511003]-[512003]-[601003] - [602103]-[611003]+[621003] | [631003]-[522003]-[523003] +[642003]+[643003]-[671003] -[672003] |
| Агаарын хөлгийн даатгал | [511008]-[512008]-[601008] - [602108]-[611008]+[621008] | [631008]-[522008]-[523008] +[642008]+[643008]-[671008] -[672008] |
| Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал | [511009]-[512009]-[601009] - [602109]-[611009]+[621009] | [631009]-[522009]-[523009] +[642009]+[643009]-[671009] -[672009] |
| Хариуцлагын даатгал | [511010]-[512010]-[601010] - [602110]-[611010]+[621010] | [631010]-[522010]-[523010] +[642010]+[643010]-[671010] -[672010] |
| Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал | [511012]-[512012]-[601012] - [602112]-[611012]+[621012] | [631012]-[522012]-[523012] +[642012]+[643012]-[671012] -[672012] |
| Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал | [511016]-[512016]-[601016] - [602116]-[611016]+[621016] | [631016]-[522016]-[523016] +[642016]+[643016]-[671016] -[672016] |
| Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал | [511017]-[512017]-[601017] - [602117]-[611017]+[621017] | [631017]-[522017]-[523017] +[642017]+[643017]-[671017] -[672017] |
| Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал | [511001]-[512001]-[601001]- [602101]-[611001]+[621001] | [631001]-[522001]-[523001] +[642001]+[643001]-[671001] -[672001] |
| Хөрөнгийн даатгал | [511002]-[512002]-[601002] - [602102]-[611002]+[621002] | [631002]-[522002]-[523002] +[642002]+[643002]-[671002] -[672002] |
| Ачааны даатгал | [511004]-[512004]-[601004] - [602104]-[611004]+[621004] | [631004]-[522004]-[523004] +[642004]+[643004]-[671004] -[672004] |
| Барилга угсралтын даатгал | [511005]-[512005]-[601005] - [602105]-[611005]+[621005] | [631005]-[522005]-[523005] +[642005]+[643005]-[671005] -[672005] |
| Газар тариалангийн даатгал | [511006]-[512006]-[601006] - [602106]-[611006]+[621006] | [631006]-[522006]-[523006] +[642006]+[643006]-[671006] -[672006] |
| Мал амьтдын даатгал | [511007]-[512007]-[601007] - [602107]-[611007]+[621007] | [631007]-[522007]-[523007] +[642007]+[643007]-[671007] -[672007] |
| Санхүүгийн даатгал | [511011]-[512011]-[601011] - [602111]-[611011]+[621011] | [631011]-[522011]-[523011] +[642011]+[643011]-[671011] -[672011] |
| Зээлийн даатгал | [511013]-[512013]-[601013] - [602113]-[611013]+[621013] | [631013]-[522013]-[523013] +[642013]+[643013]-[671013] -[672013] |
| Итгэлцлийн даатгал | [511014]-[512014]-[601014] - [602114]-[611014]+[621014] | [631014]-[522014]-[523014] +[642014]+[643014]-[671014] -[672014] |
| Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал | [511015]-[512015]-[601015]- [602115]-[611015]-[621015] | [631015]-[522015]-[523015] +[642015]+[643015]-[671015] -[672015] |

“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт,
түүнд хяналт тавих журам”-ын 5 дугаар хавсралт



**МАЯГТСЗХ04146. “.....” “ХХК-ийн 20... оны дүгээр
улирлын төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт**

/мянган төгрөгөөр

| 1. Төлбөрийн чадварын хамгийн бага үзүүлэлт / $I = \max(a) + (b); (c)$ | | | |
|---|--------------|----------------|-----------------------|
| Зүйл | Дүн | Тооцох хувь | Нийт дүн |
| (a) Нөөцийн сангийн актуар тооцоолол | | | |
| Хувь оролцоогүй гэрээний нөөцийн сангийн | | 3% | 0.0 |
| Хувь оролцоотой гэрээний нөөцийн сангийн | | 2% | 0.0 |
| Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөцийн сан | | 1% | |
| (b) Эрсдэлд байгаа даатгалын гэрээний үнэлгээ | | | |
| Өмнөх санхүүгийн жилийн төгсгөл дэх нийт эрсдэлд байгаа даатгалын гэрээний үнэлгээний | | 0.2% | 0.0 |
| (c) Зайлшгүй байх хөрөнгө /дүрмийн сангийн доод хэмжээ/ | | | |
| 2. Нийт хөрөнгө | | | |
| | Дүн | Бууруулах хувь | Тохиргоо хийгдсэн дүн |
| 3. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө | | | |
| Банкны харилцах, хадгаламж | | 0% | |
| Банкны хадгаламжийн сертификат | | 0% | |
| Касс | | 0% | |
| Засгийн газрын бонд | | 0% | |
| Төв банкны үнэт цаас | | 0% | |
| Давхар даатгалын авлага | | 0% | |
| 90 хоногоос доош хугацаанд төлөгдөөгүй байгаа авлага | | 0% | |
| Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө | | 5% | |
| Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг | | 5% | |
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас | | 8% | |
| Үл хөдлөх хөрөнгө | | 8% | |
| Хөрөнгө оруулалтын сан | Нээлттэй сан | 5% | |
| | Хаалттай сан | 10% | |
| Орон нутгийн засаг захиргааны бонд | | 10% | |
| Компанийн бонд | | 10% | |
| Хуримтлал барьцаалсан зээл | | 10% | |
| МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа | I ангилал | 20% | |
| | II ангилал | 30% | |
| Бусад авлага | | 100% | |
| Биет бус хөрөнгө | | 100% | |
| Бараа материал, тоног төхөөрөмж | | 100% | |
| Урьдчилж төлсөн зардал, тооцоо | | 100% | |
| Бусад хөрөнгө | | 100% | |
| 4. Зөвшөөрөгдөх хөрөнгө / $4 = (2) - (3)$ / | | | |
| 5. Өр төлбөр / $5 = \text{урт хугацаат өр төлбөр} + \text{богино хугацаат өр төлбөр}$ / | | | |
| 6. Төлбөрийн чадварын зохистой харьцаа / $6 = (4) / (5) \geq 110\%$ | | | |
| 7. Төлбөрийн чадварын хязгаар / $7 = (4) - (5) \geq (1)$ / | | | |